

ТЕКСТИЛИЙН ТОГТВОРТОЙ ҮЙЛДВЭРЛЭЛ MNS 6926 : 2021 ҮНДЭСНИЙ СТАНДАРТ

БАЙГАЛЬ ЭЭЛТЭЙ, НИЙГЭМД ХАРИУЦЛАГАТАЙ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨӨ



ЗОРИЛГО

**ТЕКСТИЛИЙН ТОГТВОРТОЙ
ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ЭРХЛЭХЭД
БАРИМТЛАХ ҮНДСЭН ЗАРЧИМ,
ШААРДЛАГУУДЫГ ТОГТООХ,
ТЭДГЭЭРИЙГ ҮНЭЛЭХ,
БАТАЛГААЖУУЛАХАД
ЭНЭХҮҮ СТАНДАРТЫН
ЗОРИЛГО ОРШИНО.**

Энэхүү стандарт нь байгальд ээлтэй, нийгэмд хариуцлагатай байхыг үйлдвэрлэгчээс шаардах бөгөөд тогтвортой үйлдвэрлэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, талуудын чиг үүрэг, үндсэн баримт бичгүүд болон баталгаажуулалтын үйл явцыг дэлгэрэнгүй заасан.

Стандартын хэрэглээ

Текстилийн үйлдвэрлэл эрхлэгчид болон тохирлын үнэлгээний байгууллагуудад тавих шаардлагыг тогтооход хамаарна.

Стандартын хамрах хүрээ

Текстилийн тогтвортой үйлдвэрлэл эрхэлж буй үйлдвэрлэгч болон түүнийг баталгаажуулах тохирлын үнэлгээний байгууллагууд хэрэглэнэ.

Энэхүү стандартыг AVSF Монгол байгууллагаас Европын Холбооны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Текстилийн тогтвортой үйлдвэрлэл ба эко тэмдэг" төслийн хүрээнд санаачлан боловсуулсан Монголын текстилийн тогтвортой үйлдвэрлэлийн удирдамжид тулгуурлан боловсруулж, баталсан.



Текстилийн тогтвортой үйлдвэрлэл гэж юу вэ?

Зохистой дадал нэвтрүүлсэн бэлчээрийн мал аж ахуйгаас бэлтгэсэн түүхий эдийг байгальд ээлтэй технологиор боловсруулж нэмүү өртгийн сүлжээний хүрээнд үр өгөөж, үүрэг хариуцлагыг тэгш хуваарилах зарчмыг баримтлан ил тод, тасралтгүй, ёс зүйтэй үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг хэлнэ.

Текстилийн тогтвортой үйлдвэрлэл MNS 6926 : 2021 үндэсний стандарт нь Монгол Улсын хөгжлийн бодлого "Алсын хараа - 2050", НҮБ-ын "Тогтвортой хөгжлийн зорилт - 2030" зэрэг томоохон баримт бичиг, бодлогуудтай уялдаж байна. Стандарт нь байгалийн нөөцийн зохистой хэрэглээ, нийгмийн хариуцлага, эрчим хүч болон химийн бодисын хэрэглээ, үйлдвэрлэлийн хог хаягдал, мал амьтны эрх зэрэг өргөн хүрээг хамарч байгаа юм.

